



Хууль Зүйн Яам

Эрх Зүйн Мэдэгдэл

ТҮР ХОРИОНД ОРСОН ЭТГЭЭДЭД ГАРДУУЛАХ

13 НАСНААС ДЭЭШ НАСНЫ НАСАНД ХҮРЭЭГҮЙ ИРГЭН - НИЙТЛЭГ ЭРХ ЗҮЙ

Доорх мэдээллүүдийг таны ойлгох хэл дээр бичиж өгсөн байх шаардлагатай.

Хэрвээ мэдээлэл нь таны дээд ашиг сонирхолыг хөндөөгүй эсвэл шүүхийн үйл ажиллагаанд хор хөнөөлтэй биш бол эцэг эхийн эрх эзэмшигчид ижил мэдээлэл авах болно.

Та энэ баримт бичгийг хоригдох хугацаандаа хадгалах эрхтэй.

Таныг ямарваа нэгэн шоронд яллаж шийтгэх ялтай зөрчил үйлдсэн эсвэл үйлдэхийг завдсан болоход сэжиглэх нэг эсвэл хэд хэдэн шалтгаан байгаа учраас таныг түр хорионд оруулах тухай танд мэдээлсэн болно.

Та өөрийн түр хоригдох болсон зөрчлийн үтга шинж, огноо ба байрлалыг мэдэх бүрэн эрхтэй болон өөрийг тань түр хорих болсон тодорхой шалтгаануудыг мэдэх эрхтэй.

24 цагийн хугацаатай үргэлжилж болох түр хорионы үеэр таны үйлдсэн хэргийн дагуу таныг байцаана. Энэ хугацааны эцэст хэрвээ таны үйлдсэн хэргийн шийтгэлээр танд нэг жилийн хорих ял оноох бол Улсын прокурор эсвэл хүүхдийн эрх хариуцсан шүүгч нар, хэрвээ таны үйлдсэн хэрэг дор хаяж нэг жилийн шийтгэлтэй тохиолдолд, таны түр хорих хугацааг дахин 24 цагаар үргэлжлүүлэн сунгах эсэхийг шийдэх эрхтэй. Хэрвээ та 16-аас доош настай бол хэрвээ таны сэжиглэгдэж байгаа хэрэг 5 жил ба үүнээс дээш хугацаатай шийтгэлтэй тохиолдолд л зөвхөн сунгалт хийж болно. Та шүүх хуралд оролцоно, үгүй бол видео шүүх хуралд оролцох болно.

Энэ хорих хугацаа дуусахад Улсын прокурорын эсвэл анхан шатны шүүгчийн шийдвэрийн дагуу эсвэл хүүхдийн эрхийн шүүгчийн шийдвэрийн дагуу таны хэргийг захиргааны шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой эсвэл таныг суллан чөлөөлж болно. Эхний тохиолдолд та түр хорих хугацаа дууссанаас тоолон 20 цагийн дотор та шүүх хурлаар орж шүүгчээр хэргээ шийдүүлнэ.

Үүнээс гадна та дор дурдсан эрхтэй:

Ойрын хүмүүст мэдээлэл хүргэх

Таны эцэг эхэд эсвэл таны асран хүмүүжүүлэгчид, эсвэл таныг хариуцсан хүмүүжүүлэгчид таныг түр хорионд орсны тухай заавал мэдэгдэх ба үүний зэрэгцээ үйлдсэн хэргийн шинж байдал, огноо ба үйлдсэн хэргийн байрлалын тухай мэдэгдэнэ.

Та хамт амьдардаг хүмүүст эсвэл эцэг эхийнхээ аль нэгэнд эсвэл ах эгчийнхээ аль нэгэнд эсвэл өөрийнхөө куратор эсвэл өөрийн хүмүүжүүлэгчдээ түр хорионд орсон арга хэмжээний тухай утсаар холбогдож мэдүүлэх эрхтэй.

Та мөн өөрийн ажил олгогчдоо энэ мэдээг хүргэж болно.

Хэрвээ та гадаад улсын иргэн бол та өөрийн улсын консулын газарт үүний тухай мэдээлж болно.

Даван гарах боломжгүй тохиолдлуудаас бусад тохиолдлуудад шүүгчид өргөдлөө гаргасан хугацаанаас 3 цагаас хэтрэхгүй хугацаанд яаралтай уг хэрэгт оролцоно.

Улсын прокурор, анхан шатны шүүгч эсвэл хүүхдийн эрхийн шүүгч амь насанд буюу эрх чөлөөнд эсвэл хэн нэгний бие махбодид халдсан нотолгоо цуглуулах шаардлагатай бол хүсэлтийг хойшлуулах эсвэл дамжуулах боломжгүй зэргийг шийдэх эрхтэй. Таны хуулийн төлөөлөгчдийн санал бодлыг хэрвээ түр хорих арга хэмжээг сунгах бол 24 цагаас хэтрэхгүй хугацаанд авах, үгүй бол арван хоёр цагаас хэтрэхгүй хугацаанд хүлээж авна.

Хэн нэгэнтэй холбоо барих

Та өөрийнхөө түр хорионд орсон тухай мэдэгдэх шаардлагатай бол түүнтэй бичгээр, утсаар эсвэл ярилцлага хийж холбогдож болно.

Шүүхийн цагдааны хэлтэсийн албан хаагч нь хэрвээ уг хүсэлт таны хоригдох болсон хэргийн шалтгаануудтай

тохирохгүй байх, эсвэл үүнээс үүдэж аливаа нэгэн зөрчил үүсэх эрсдэл бий гэж үзвэл таны хүсэлтийг хүлээн авахгүй байж болно. Тэр түүний эсвэл өөр нэгэн албан хаагчийн хяналтан дор 30 минут үргэлжлэх уулзалтын хугацаа, уулзалтын нөхцөл байдал, огноо, цаг өдөр зэргийг тодорхойлно.

Эмчийн үзлэгт хамрах

Хэрвээ та 16 наснаас доош настай тохиолдолд та зайлшгүй эмчийн үзлэгт хамрана. Түр хорих хугацааг сунгасан тохиолдолд таныг дахин эмчийн үзлэгт хамруулна.

Хэрвээ та 16 наснаас дээш настай тохиолдолд түр хорих арга хэмжээний эхэнд та эмчийн үзлэгт орох хүсэлт гаргаж болно. Түр хорих хугацааг сунгасан тохиолдолд та дахин эмчийн үзлэгт хамрах хүсэлт гаргаж болно. Энэ хүсэлтийг таны эцэг эх, асран хүмүүжүүлэгч эсвэл шүүхийн байгууллагаас таныг итгэмжилсэн хүн зэрэг хүмүүс гаргаж болно. Таны өмгөөлөгч мөн адил таныг эмчийн үзлэг хамруулах хүсэлт гаргаж болно.

Мэдэгдэл хийх, асуултанд хариулах эсвэл үг хэлэхгүй байх

Та өөрийн биеийн байцаалтыг хойшлуулсан бол шүүх хурлуудын үед та доорх эрхийг эдэлнэ:

- мэдэгдэл гаргах,
- таниас асуусан асуултад хариулах
- үг хэлэхгүй байх.

Хууль зүйн төлөөлөгчтэй хамт хүрэлцэн ирэх

Хэрвээ мэргэжлийн байгууллагаас зайлшгүй шаардлагатай гэж үзвэл, та өөрийнхөө шүүх хуралд эсвэл байцаалтуудад эцэг эхийн талын хариуцлага хүлээсэн хүнтэй хамт хүрэлцэн ирж болно. Үгүй бол та хэн нэгэн өөр насанд хүрсэн хүнийг тантай хамт хүрэлцэн ирэх эсвэл шүүхийн байгууллагаас томилсон насанд хүрсэн хүнтэй хамт хүрэлцэн ирнэ.

Өмгөөлөгчийн туслалцаа авах

Түр хорионд орсноос эхлэн та заавал өмгөөлөгчийн туслалцаа авна.

Өмгөөлөгчийн сонголт

Түр хорих ажиллагаа эхлэснээс тооцон шүүх хурлын аливаа нэгэн мөч хүртэлх хугацаанд түр хорих хугацаа сунгасан тохиолдолд энэ сунгалтын эхэнд та өөрийн сонголтоор өмгөөлөгчийн туслалцаа нэхэх эрхтэй. Хэрвээ та өмгөөлөгч авч чадахгүй эсвэл өмгөөлөгчтэй холбоо барих боломжгүй бол шүүхийн цагдаагийн хэлтэсийн ажилтан эсвэл Улсын прокурор, анхан шатны шүүгч эсвэл хүүхдийн эрхийн шүүгч нь зохих өмгөөлөгчийг танд туслуулах зорилгоор томилно.

Таны өмгөөлөгчийг таны эцэг эх, эсвэл асран хүмүүжүүлэгч эсвэл таныг хариуцаж байгаа албаны ажилтан томилж болно.

Өмгөөлөгчийн туслалцаа ба оролцооны хугацаа

Өмгөөлөгч нь ярилцлагын нууцыг хадгалсан нөхцөл байдалд тантай 30 минутын хугацаанд ярилцах эрхтэй; хорих хугацааг сунгасан тохиолдолд та өөрийнхөө өмгөөлөгчтэй дахин уулзах хүсэлтийг дахин гаргаж болно.

Үүний зэрэгцээгээр тэр хэрвээ таныг хүсэлт гаргасан тохиолдолд таны маргаан шийдвэрлэх, шүүх хуралд оролцох, таны үйлдсэн үйлдлүүдийг давтах, үйлдлүүдийг тодорхойлох хэрэгт оролцож болно.

Энэ тохиолдолд таны анхны шүүх хурал хэрвээ зөвхөн таны биеийн байцаалт дээр тулгуурлаж байгаа тохиолдолд ажиллагаагаа таны хүсэлт гаргаснаас 2 цагийн хугацаа өнгөрөөгүй байхад таны өмгөөлөгчгүй эхлэхгүй.

Гэсэн хэдий ч таны анхны шүүх хурал таны өмгөөлөгчийн эзгүйд ч гэсэн Улсын прокурорын зөвшөөрлөөр (анхан шатны шүүгч эсвэл хүүхдийн эрхийн шүүгчийн хүсэлтээр) хэрвээ байцаалт нь үүнийг шаардаж байвал тэр дороо эхэлж болно.

Хэрвээ таны өмгөөлөгч шүүх хуралд оролцож байхад ямарваа нэгэн маргаан үүсвэл шүүх хурал нь таны хүсэлтээр таныг өмгөөлөгчтэй зөвлөлдөх боломж олгох зорилгоор түр завсарлаж болно.

Улсын прокурор, анхан шатны шүүгч эсвэл хорих эрх чөлөөний шүүгч нь гэнэтийн шалтгаанаар маш онцгой гойд тохиолдолд таны өмгөөлөгчийн шүүх хуралд оролцох туслалцааг, хэрвээ таван жилд шоронгийн ял эдлэх бол, дээд хэмжээгээр 12 цагаар, нэг удаа шинэчлэх эрхтэйгээр хойшлуулан түдгэлзүүлж болно.

Хэлмэрчийн туслалцаа авах

Хэрвээ та франц хэлээр ярьдаггүй ба ойлгодоггүй бол та хурлуудынхаа үеэр болон өмгөөлөгчтэйгөө харилцахаар хэлмэрчийн туслалцааг үнэ төлбөргүй шүүх авах эрхтэй.

Түр хориог эцэслэх хүсэлт гаргах

Та Улсын прокурорт эсвэл анхан шатны шүүгчид эсвэл хүүхдийн эрхийн шүүгчид шүүх түр хорих хугацааг сунгах шийдвэр гаргасан тохиолдолд дахин сунгахгүй байх хүсэлт гаргаж хандах эрхтэй.

Хэргийнхээ зарим хэсгүүдтэй танилцах

Таны хүсэлтээр эсвэл таны өмгөөлөгчийн хүсэлтээр та өөрийн түр хориог сунгахын өмнө доорх байдлуудтай танилцах эрхтэй:

- таныг түр хорионд оруулах тухай протоколын мэдэгдэл;
- таныг үзсэн эмчийн гаргасан эрүүл мэндийн гэрчилгээ эсвэл гэрчилгээнүүдтэй танилцах,
- шүүх хурлуудын протоколуудтай танилцах.

Улсын прокурорт танилцуулах

Түр хорионы эцэст та нэг жилийн хугацаанд Улсын прокурорт баталгаатай захидлаар эсвэл нотариатын нотолгоотой итгэмжлэлээр өөрийн танилцуулгыг боловсруулах зорилгоор өөрийнхөө хэрэгтэй танилцах мэдэгдэл гаргаж болно.

Хувийн нууцлалын эрх

Энэхүү арга хэмжээнд таны оролцсон шүүх хурлуудын видео хальсанд бичлэг хийх зэргийн үйлдлүүд ордог. Энэ бичлэгүүдийг хэн нэгэнд нэвтрүүлэн үзүүлэхийг хориглоно.

Бичлэгүүдийг хаалттай нөхцөлд зохих мэргэжилтэн хүмүүст үзүүлж болох ба үүний улмаас шүүх хурлын ярилцлагын тайлагналыг нийтлэхийг хориглодог ба таныг тодорхойлох бүх хэсгүүдийг үзүүлэхийг хориглодог.